



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/58

Улаанбаатар хот

Түр журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 47 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймаг, сум, тосгон, багийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс танхимаар зохион байгуулсугай.

2. “Хүүхдийн цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг танхимаар зохион байгуулах түр журам”-ыг нэгдүгээр, “Ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг танхимаар зохион байгуулах түр журам”-ыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

3. Хичээл, сургалтын үйл ажиллагааг танхимаар эхлүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтанд тус тус үүрэг болгосугай:

3.1. Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 18 дугаар тушаалаар баталсан “Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам” болон энэ тушаалын хавсралтаар батлагдсан түр журмыг өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, сургуулийн багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад танилцуулж, бэлэн байдлыг хангах арга хэмжээ авахыг Сургуулийн өмнөх боловсролын газар /Ж.Мягмар/, Бага, дунд боловсролын газар /Т.Ням-Очир/, Тусгай хэрэгцээт боловсролын хэлтэс /Ч.Ганцэцэг/, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын дарга нарт;

3.2. Танхимын сургалтаар суралцагчийн зайнаас суралцсан агуулгыг бататгах арга зүйн зөвлөмжөөр цэцэрлэг, сургуулийн удирдах ажилтан, багш нарыг хангаж ажиллахыг Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын дарга нарт;

3.3. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, суралцагч, багш, ажилтанд гарч болзошгүй айдас, түгшүүр, эргэлзээг тайлах нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх арга зүйн сургалтыг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын дарга, мэргэжилтэнд цахим хэлбэрээр зохион байгуулахыг Багшийн мэргэжил дээшлүүлэх институт /Ж.Болормаа/-д;


3.4. Энэ тушаалын 3.3-д заасан сургалтыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал, багш, ажилтанд

142110223

зохион байгуулахыг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын дарга нарт;

3.5. Цэцэрлэг, сургууль орчмын бүсэд орон нутгийн холбогдох мэргэжлийн байгууллагуудын хамтарсан ажлын хэсгээр эрсдэлийн үнэлгээ хийлгэж, хариу арга хэмжээ авч ажиллахыг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын дарга, цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал нарт.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаярт даалгасугай.

САЙД  Л.ЭНХ-АМГАЛАН